

Удирдлага зохион байгуулалт:

1. 2024 оны 07-р сарын 04-ний сумын Удирдах ажилтны шуурхай хурал болж Баяр наадмын бэлтгэл ажлын явцтай танилцаж, эрчимжүүлэх үүрэг өглөө.
2. Аймаг, сумын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн хүрээнд 4-р цэцэрлэг нь хариуцсан талбайн тохижилтын ажлаа хийж дуусгав.
3. Төрийн албаны өдрөөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх арга хэмжээнд сумын 13 албан хаагч хамрагдаж, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн Төрийн албан хаагчийн тангараг өргөлөө.
4. НҮБ-ын Хүн амын сангаас сумын 10 малчин эмэгтэйчүүдэд эрүүл ахуй ариун цэврийн багцыг гардан авсан.
5. 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Төрийн байгууллагуудын удирдах ажилтнуудын сургалт, зөвлөгөөнд 4 удирдах албан хаагч хамрагдсан.

Төсөв, санхүү

2024 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 100,850.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 174,293.8 мянган төгрөг буюу 172.8 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 4,754.5 мянган төгрөг , авлага 3,576.8 мянган төгрөг байна. Үүнд: Тайлант онд ЕБС-ийн түлш халаалтын зардалд 1,860.8 мянган төгрөг, урьд оны НДШ-ийн өглөг 2,893.7 мянган төгрөгийн өглөгтэй байна

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/35 дугаар захирамжаар ХАА2, ХАА3 маягтуудын мэдээллийг оны эхэнд Сумын багийн Засаг дарга нар гаргаж, сумын санхүү албаны төрийн сангийн мэргэжилтэн medee.app.nso.mn программ шивж байна. Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар малын хорогдлын мэдээгээр үхэр- 1182 ширхэг, Адуу-1517 ширхэг, Хонь-12931 ширхэг, Ямаа – 8251 ширхэг нийт 23881 мал хорогдсон байна. Мөн 2024 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар нийт 8384 мал төллөж үүнээс 6703 төл бойжиж, 1681 төл хорогдсон байна.

Сумын 30 жилийн ойн хүрээнд 2024 он 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж ХХҮГ-тай хамтран Баянтал суманд гэрээгээр ажиллаж буй 3 хүн, Баянтал сумын ЗДТГ-ын хогны машины жолооч 1 хүн нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй 5 хогийн савийг будаж, өнгө үзэмж оруулан ажиллаа.

Анхны байдал

Буддаж байгаа байдал

Будаж дууссан байдал

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН:

Сумын баяр наадмын тохижилтыг ажлыг үргэлжлүүлэх ажлын хүрээнд 4 арга хэмжээний шууд худалдан авалтын гэрээ байгуулсан. Үүнд:

- ❖ Бөхийн асар, майхан-12,000,000 төгрөг
- ❖ Стандарт нойл-4,000,000 төгрөг
- ❖ Зөөврийн тайзны суурь-3,059,200 төгрөг

❖ Зөөврийн угсардаг тайз-15,748,500 төгрөг

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН:

Баянтал суманд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг нь 2024 оны 07-р сарын 02-ны өдөр хуралдаж сонгон шалгаруулалтыг хийж ажилласан. Нийт суманд газар эзэмшихээр 2 төсөл ирсэн. Дээрх 2 төсөл нь төсөл сонгон шалгаруулах болзол шаардлага хангасан тул хүссэн газрыг нь олгохоор шийдвэрлэв.

НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Сүмбэр сумын Сансар ууланд хийж байгаа археологийн малтлагын ажилд 7-р сарын 4-5-ны өдрүүдэд гэр болон бусад материаллаг зүйлээр тусламж үзүүлж ажилласан. Соёл урлагийн газраас Сумын Соёлын төвд 145 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, notebook, принтер зэргийг хөрөнгө оруулалт хийсэн.

Эрүүл мэндийн төвөөс 3 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулж Хөдөө, төвийн айлуудаар “Зудын үеийн нялх бага насны хүүхэд, хөхүүл эх, жирэмсэн эхэд олон найрлагат бичил тэжээл болон Д витамин” тарааж 10 өрхийн 11 хүүхэд 1 жирэмсэн эхэд үзлэг хийсэн.

- ▶ Амбулаторын үзлэг- 35
- ▶ Яаралтай тусламж- 34
- ▶ Идэвхитэй хяналт-2
- ▶ Өдрийн эмчилгээ- 5
- ▶ Хэвтэн эмчлүүлсэн- 24
- ▶ Гэрийн эргэлт - 2
- ▶ Нярайн эргэлт- 2
- ▶ Товлолт дархлаажуулалт -8
- ▶ Алсын дуудлага Том хүн- 1 хүүхэд-0
- ▶ Ойрын дуудлага-Том хүн-5 хүүхэд- 5
- ▶ Зам тээврийн осол- 0
- ▶ Сахарын шинжилгээ - 2
- ▶ Тэмбүү-8
- ▶ Дох-8
- ▶ Ц Верус-8
- ▶ Б. Верус-8


БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Сум байгуулагдсаны түүхт 30 жилийн ойн баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд хийсэн тохижилт засварын ажлууд



БАЯР НААДМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

сум байгуулагдсаны түүхт 30 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 07-р сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулав.





БАЯНТАЛ СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР